



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 1104

Шивээговь сум

Нийтийн их цэвэрлэгээ, ногоон
байгууламжийн усалгаа, арчилгаа
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.л, 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.7, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5, 9.4.12, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын төвийн нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх бүх нийтийн их цэвэрлэгээг 14 хоног тутмын Баасан гарагт суманд үйл ажиллагаа явуулж буй бүх албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүд тогтмол зохион байгуулсугай.

2. Нийтийн их цэвэрлэгээний хуваарийг 1 дүгээр хавсралтаар, албан байгууллага, аж ахуйн нэгжийн ногоон байгууламжийн цэвэрлэгээ, хуваарьт талбайн усалгаа, арчилгаа, хашааг засах, босгох хуваарийг 2 дугаар хавсралтаар, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хуваарийн дагуу өөрийн байгууллагынхаа хуваарьт газруудад цэвэрлэгээ, усалгаа арчилгаа хийлгэх, багаж хэрэгслээр хангах, цэвэрлэгээний ажилд ажилтан, албан хаагчдаа бүрэн хамруулах, цэвэрлэгээг чанартай хийж гүйцэтгэхийг албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Сумын төвийн нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх бүх нийтийн их цэвэрлэгээг тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулж ажиллахыг 1, 2 дугаар багийн Засаг дарга нарт, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны мэргэжилтэн, Байгаль хамгаалагч нарт үүрэг болгосугай.

42120011

5. Хууль тогтоомж зөрчигчдөд хариуцлага тооцож ажиллахыг улсын байцаагч, цагдаа, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тухай бүр танилцуулахыг Засаг даргын орлогч /Ж.Батмөнх/-д даалгасугай.

ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ


Сумын Засаг даргын 2020 оны 01-р сарын 13 ний едрийн АОН дугаар захирамжийн 1-р хавсралт

2020 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ НИЙТИЙН ИХ
ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ХУВААРЬ

Сар	Өдөр																																
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31		
1	■																																
2																																	
3																																	
4																																	
5																																	
6																																	
7																																	
8																																	
9																																	
10																																	
11																																	
12																																	

Жич: Нийтийн их цэвэрлэгээний хуваарт тодорхой шалтгаанаар еөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр мэдэгдэнэ. Баяр ёслолын үер хуваарь харгалзахгүй цэвэрлэгээ хийгдэнэ.

Ногоон байгууламжийн хашаа сэргээн засварлах, усалгаа, арчилгаа, цэвэрлэгээний ажлыг хийх, хуваарийн зураглал



Э
М
Т

Э
М
Т

Э
М
Т

ЗДТГ

ЗДТГ

Нарлаг Шивээ СӨХ

Илчлэг шивээ ОНӨҮГ



Энд байрлах ААНБ-ууд замын урд хэсгийн хашааг цэвэрлэнэ

Сумын Засаг даргын 2020 оны 4-р
сарын 13 ний өдрийн 1104 дугаар
захирамжийн 8-р хавсралт

НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ХАШААГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ, УСАЛГАА,
АРЧИЛГАА, ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖЛЫГ ХИЙХ ХУВААРИЛАЛТ

1. "Шивээ-Овоо" ХК, "Шивээ-Сервис" ХХК, ШОХК-ний халаалтын зуух,
Нарлаг Шивээ СӨХ
 - 1.1 ШОХК-ийн конторын эргэн тойрон 200 метр талбай, төв талбайн ногоон байгууламж
 - 1.2 Орон сууцны 9,10-р байрны эргэн тойрон 200 метр талбай, урагшаа Бизнес хөгжлийн төв хүртэл
 - 1.3 Орон сууцны 12,13,14,15-р байрны эргэн тойрон, халаалтын зуухны 50 метр, баруун тийш 10-р байр хүртэл, зүүн тийш автогражийн зүүн тал хүртэл
 - 1.4 Бизнес хөгжлийн төв, спорт заалны эргэн тойрон 50 метр газар
 - 1.5 Нарлаг Шивээ СӨХ, ногоон байгууламжийн хуваарьт талбай
2. Тохилог Сууц Өмчлөгчдийн Холбоо
 - 2.1 Орон сууцны 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 –р байрны ойр орчмын 50 метр газар, автогражийн ойр орчмын газар, ногоон байгууламжийн хуваарьт талбай
3. "Нэгүн" паб рестран, худалдааны төв, "Чингүн агь"
Байгууллагын эргэн тойрон 50 метр, урагшаа ногоон байгууламж хүртэл
4. "Илчлэг Шивээ" ОНӨҮГ
 - 4.1 Хойд талын чулуун хашааны гаднах 100 метр, өөрийн хашааны дотор конторын орчин, байгууллагын эргэн тойрны 100 метр газар, сумын төвийн ногоон байгууламжийн хуваарьт талбай
5. 3 дугаар сургууль
 - 5.1 Зүүн тийш 3-р цэцэрлэг, урагшаа эмнэлгийн чулуун хашаа, хойшоо 100 метр газар, сумын төвийн ногоон байгууламжийн хуваарьт талбай
6. Эрүүл мэндийн төв
 - 6.1 Байгууллагын эргэн тойрны 100 метр талбай, сумын төвийн ногоон байгууламжийн хуваарьт талбай
7. Нутгийн удирдлагын ордонд байрлах байгууллага нэгжүүд
 - 7.1 Байгууллагын эргэн тойрны 100 метр газар, Захиргааны хойд талын цэцэрлэгт хүрээлэнгийн газар
8. Холбооны салбар, "Оюу" маркет, Төрийн банк, "Чойр Хайрхан сүмбэр" ХХК, "Магнай алаг" ХХК, "Хаан банк", "Төрийн банк", болон түрээслэгчид, махны дэлгүүр
 - 8.1 Өөрсдийн байгууллагын эргэн тойрон 50 метр, урагшаа ногоон байгууламж хүртэл

9. "Хөгжил" ЗБН, "Тулга" цайны газар, Биллъярд, "ОД" хүнсний дэлгүүр, "Нэртийн булаг" хүнсний дэлгүүр
- 9.1 Байгууллагын эргэн тойрны 50 метр талбай, ногоон байгууламж хүртэл
- 10.3 дугаар цэцэрлэг, "Баян богд худалдааны төв"
- 10.1 Өөрсдийн байгууллагын ойр орчмын 100 метр газар, Сумын төвийн ногоон байгууламжийн хуваарьт талбай
11. "Оргил" худалдааны төв
- 11.1 Байгууллагын ойр орчмын 100 метр талбай
12. Цагдаагийн хэсэг
- 12.1 Байгууллагын ойр орчмын 100 метр талбай, ногоон байгууламжийн хуваарьт талбай
13. "НИК" ШТС, "Сод Монгол" ШТС
- 13.1 Эргэн тойрон 100 метр газар
14. Орон сууцны байранд үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ууд
- 14.1 Эргэн тойрны 50 метр газар
15. Гэр байранд үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ууд
- 15.1 Өөрсдийн байгууллагын гаднах орчин, эргэн тойрны газрыг цэвэрлэх
16. Зүүн гэр, урд гэр хороололын бүх айл өрхүүд өөрсдийн хашааны гаднах газрыг цэвэрлэх, их цэвэрлэгээнд хамрагдах
17. Орон сууцны айл өрхүүд орц болон гаднах орчноо цэвэрлэх

Сумын Засаг даргын оны ...р
сарын ... ний өдрийн дугаар
захирамжийн ...-р хавсралт

Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

43.1. Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол улсын байцаагч, цагдаа болон сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга дараахь хариуцлага хүлээлгэнэ:

43.1.3. Энэ хуулийн :

10.2.4. Хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх

10.2.5. Үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх

10.2.7. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх

10.2.9. Эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх

10.2.10. Энэ хуулийн 9.4.12-т заасан нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх

10.2.11. Барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах

Дээрх заалтуудад заасныг зөрчсөнө бол хүнийг гучин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.4 Энэ хуулийн:

10.3.1. Хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях

10.3.2. Нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хог хаягдал хаяхыг хориглоно

Дээрх заалтуудыг зөрчсөн бол хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох

43.1.5 Энэ хуулийн:

10.3.3. Хог хаягдлыг ил задгай шатаахыг хориглоно

10.3.4. Гэрийн болон нам даралтын зууханд нийлэг материалтай хог хаягдлыг шатаахыг хориглоно,

Дээрх заалтуудыг зөрчсөн бол хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.6 Энэ хуулийн:

10.3.5.Хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаяхыг хориглоно.

Дээрх заалтыг зөрчсөн бол хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.7 Энэ хуулийн:

10.3.6.Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулах;

Дээрх заалтыг зөрчсөн хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.8 Энэ хуулийн:

10.3.7.Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө дээр зар сурталчилгаа байршуулах, шашны болон зан үйлийн эд зүйлс тавьж хог хаягдал үүсгэх.

Дээрх заалтыг зөрчсөн хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.9 Энэ хуулийн:

14.5 Хог хаягдлаа хог хаяг цуглуулж, тээвэрлэх, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх,

Дээрх заалтыг зөрчсөн хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун мянган төгрөгөөр торгох;

43.4.14 Энэ хуулийн:

20.4.Тогтоосон цэгээс бусад газарт хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно

Дээрх заасныг зөрчсөн хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

43.1.19.Нийтийн эдэлбэр газар болон ногоон бүсэд хог хаягдал хаясан иргэн, аж ахуйн нэгжийн зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг хурааж, зөрчил гаргасан хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван сая төгрөгөөр торгох;

Ойн тухай хууль

13.1.19.мод бэлтгэсэн, ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, говь, хээрийг ойжуулах, ойн зурвас байгуулах, төв, суурин газрыг цэцэрлэгжүүлэх ажлыг төв, орон нутгийн түвшинд зохион байгуулах;

18.2.4.ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийн түймрээс хамгаалах талаарх ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, тэдний тарьж ургуулсан таримал ойг хүлээн авах;

Зөрчлийн тухай хууль

10.Ойн тухай хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.